

Үйлчилгээний нөхцөл

1. **Онлайн худалдаа**

- 1.1. Интернет худалдааг сайтаас зохион байгуулах бөгөөд хэрэглэгчийн худалдан авсан барааг **Түгээлтийн өдөр, цагийн хуваарийн дагуу “Монгол шим”-ийн ҮҮР**-энд хүргэнэ.
- 1.2. **Түгээлтийн өдөр** гэдэг нь хэрэглэгчийн худалдан авсан барааг Монгол шимийн ҮҮР-энд хүргэх тодорхой тогтсон өдөр байна.
- 1.3. **Түгээлтийн цагийн хуваарь** гэдэг нь Зөвхөн түгээлтийн өдөрт хамаарах 2-3 цагийн турш үргэлжлэх хугацаа байна.
- 1.4. **Монгол шим**-ийн **ҮҮР** гэдэг нь үйлдвэрлэгч, болон хэрэглэгч нар уулзах тодорхой тогтсон байршлийг хэлнэ.
- 1.5. Түгээлт эхлэхээс 72 цагаас багагүй хугацааны өмнө **ҮҮР**-ийн гишүүдэд худалдаа нээх мэдэгдлийг и-мэйлээр хүргүүлснээр online худалдаа нээгдэнэ.
- 1.6. Худалдаа нээлттэй байх хугацаанд хэрэглэгч интернэтээр төлбөрөө төлж бүтээгдэхүүнээ захиална.
- 1.7. Хэрэглэгч захиалгаа Түгээлтийн өдөр “Монгол Шим-ийн ҮҮР-энд захиалгын баримтын хамт ирж авна.
- 1.8. Худалдааны үргэлжлэх хугацаа нь худалдаа нээгдсэнээс түгээлтийн өмнөх өдрийн 17:00 цаг хүртэл үргэлжлэх бөгөөд автоматаар хаагдсанаар дуусгавар болно.

2. **Захиалга хүлээн авах, баталгаажуулах**

- 2.1. Үйлдвэрлэгчийн санал болгосон сайтан дээрх үнэ, зураг бүхий бүтээгдэхүүнээс хэрэглэгч өөрт тохирсон бүтээгдэхүүнийг сагсанд цуглуулан төлбөр хийж захиалгаа хийнэ.
- 2.2. Үйлдвэрлэгч өөрт ирсэн захиалгын дүнгээс хамаарч түгээлт эхлэхээс 12 цагийн өмнө хүргэх эсэхээ шийдэж, шийдвэрээ баталгаажуулна.

- 2.3. Үйлдвэрлэгч дараах тохиолдолд бүтээгдэхүүнийг хүргэхгүй байж болно.
Үүнд:
- 2.3.1. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хүргэж чадахгүй тохиолдолд
 - 2.3.2. Тухайн үеийн нөхцөлд үйлдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд.
Энэ нөхцөлд үйлдвэрлэгч яагаад хүргэх боломжгүй болсоноо Үүрийн зохион байгуулагчид тайлбарлах үүрэгтэй.
 - 2.3.3. Захиалга хүргэх хамгийн бага үнийн дүнгийн босгыг хангаагүй тохиолдолд

3. Төлбөр тооцоо хийх аргачлал

- 3.1. Бүтээгдэхүүний үнэ болон савалгааны хэмжээг үйлдвэрлэгч тухайн худалдаа нээгдсэнээс түгээлт хүртэлх хугацаанд өөрчлөхгүй.
- 3.2. Бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь сайтад үйлдвэрлэгчийн санал болгосноор байрших бөгөөд түгээлтийн өдөр үүрэн дээр хүргэхэд ямар нэгэн нэмэгдэл өртөггүйгээр захиалгын хуудсан дээр бичигдсэнээр байна.
- 3.3. Хэрэглэгч зөвхөн онлайн худалдаа нээлттэй байх үед захиалга өгөх, төлбөр хийх боломжтой.
- 3.4. Хэрэглэгчид хүргэгдээгүй бүтээгдэхүүний төлбөрийг Түгээлтийн хугацаа дууссанаас хойш хэрэглэгчийн дансанд 6 цагийн дотор буцаан шилжүүлнэ.
- 3.5. **“Монгол шим”-ийн ҮҮР-эн** дээр түгээлт дууссанаас хойш 12 цагийн дотор борлуулсан бүтээгдэхүүний төлбөрийг үйлдвэрлэгчид шилжүүлнэ.
- 3.6. Тус Сайт нь бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтаас сайтын үйлчилгээний хөлсөнд **19 хувийн** шимтгэл авна.
- 3.7. Төлбөр тооцоог хийхдээ сайтын санал болгосон төлбөрийн системийг ашиглана.

4. Бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлт

Үйлдвэрлэгч баталгаажсан захиалгын хуудсын дагуу нийт тоо хэмжээ, чанарын шаардлага хангасан fresh /шинэхэн/ бүтээгдэхүүнийг **“Монгол шим”-ийн ҮҮР-энд** түгээлтийн өдөр түгээлтийн цаг эхлэхэд хүргэсэн байна.

- 4.1. Хүргэлтийг Үйлдвэрлэгч өөрийн хүргэлтийн үйлчилгээгээр “**Монгол Шим**”-ийн **ҮҮР**-энд хүргэх эсвэл сайтын санал болгосон хүргэлтийн үйлчилгээний аль нэгийг өөрт тохируулан сонгоно.
- 4.2. Хэрэглэгч захиалсан бүтээгдэхүүнээ “Монгол Шим”-ийн үүрнээс ирж амжихгүй бол сайтын санал болгосон хүргэлтийн үйлчилгээний нэмэлт төлбөр төлж гэрийн хаягаараа хүргүүлж болно.

5. **Борлуулалтын зохицуулалт**

- 5.1. Зарим төрслийн амархан мууддаг бүтээгдэхүүнийг буцаалт хийх боломжгүй. Үүнд: цэцэг, бэйкэри, жимс, мах болон бусад өдөр тутмын хүнс орно.
- 5.2. Борлуулалтын буцаалтыг түгээлтийн хугацаа дууссанаас хойш 3 цагийн дотор шийднэ.

6. **Нууцлалын баталгаа**

6.1. **Баталгаа**

Үйлчлүүлэгч, хэрэглэгчдийнхээ мэдээллийн нууцлалын халдашгүй байдлыг техникийн боломжийн хүрээнд бүрэн хангаж ажиллана. Та манай вэб хуудсаар үйлчлүүлж байгаа нь дараах нууцлалын баталгааг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

6.2. **Хэрэглэгчийн хувийн мэдээлэл**

Таны вэб хуудсанд оруулж өгсөн мэдээлэл манай мэдээллийн баазад аюулгүйгээр хадгалагдах бөгөөд хэн нэгэн гуравдагч этгээдэд дамжуулахгүй.

6.3. **Мэдээллийн хамгаалалт**

Таны мэдээллийг хүлээн авахдаа бид SSL буюу мэдээллийг өндөр нууцлалтайгаар интернэтээр дамжуулах технологи хэрэглэнэ. Та өөрөө мэдээллийн аюулгүй байдлаа хангах үүднээс гуравдагч этгээдэд нэвтрэх нэр, нууц үгээ дамжуулахгүй байх, бүртгэлээсээ гарч браузерээ хааж байна уу!

6.4. **Мэдээллийн халдашгүй байдал**

Эрх бүхий хууль хяналтын байгууллагын албан ёсны шаардлагаас бусад

ямар ч нөхцөлд мэдээллийн нууцыг бусдад дамжуулахгүй чандлан хадгална.

6.5. Насанд хүрээгүй хэрэглэгчдэд үйлчлэхгүй.

7. Санал гомдлыг шийдвэрлэх

7.1. Хэрэглэгч бүтээгдэхүүний талаар санал гомдлоо Монгол шим-ийн ҮҮР-ийн зохион байгуулагчид гаргана. Үүрийн зохион байгуулагч санал гомдлыг үйлдвэрлэгчид дамжуулах үүрэгтэй бөгөөд үйлдвэрлэгчийн өмнөөс ямар нэгэн тайлбар хийхийг хориглоно. Үйлдвэрлэгч хэрэглэгчийн өгсөн санал гомдолд аль болох шуурхай хариулт өгнө.

БАЯРЛАЛАА

МОНГОЛ ШИМ
төслийн хамт олон